

## Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан

Иновэйшн Инвестмент ХК нь хувьцаагаа олон нийтэд санал болгож 2023/12/04-ний өдрөөс 2023/12/08-ны өдрийн хооронд Монголын хөрөнгийн бирж дээр анхдагч зах зээлийн захиалга авч 8.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.

2024 оны эхний хагас жилийн байдлаар Иновэйшн Инвестмент ХК-ийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт дараах байдалтай байна. Үүнд:

№	Хөрөнгө оруулалтын зориулалт	Эзлэх хувь	Татан төвлөрүүлсэн мөнгөн дүн	Зарцуулсан дүн
1	Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааны тэлэлт	22.5%	1,871,991,911	0
2	Дунд хугацааны төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа	30.0%	2,495,989,215	0
3	Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа	15.0%	1,247,994,608	609,777,709
4	“ККТТ” ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр	25.0%	2,080,003,050	2,080,003,050
5	Олон улсын зах зээлд үйл ажиллагаа өргөжүүлэхтэй холбогдуулан хүний нөөц, менежментийн ур чадварыг сайжруулах	7.5%	623,985,266	0
	<b>НИЙТ</b>	<b>100.0%</b>	<b>8,319,964,050</b>	<b>2,689,780,759</b>

2023 оны 12 дугаар сард нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 25% буюу “ККТТ” ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр болох 2,080,003,050 төгрөгийг зориулалтын дагуу ККТТ ХХК руу шилжүүлсэн.

2024 оны 6 дугаар сард төлөвлөж байсны дагуу QРау төлбөрийн системийн суурь дэд бүтцийн шинэчлэлийн хүрээнд Суурь дэд бүтцийн сервер, тоног төхөөрөмжийг шинээр худалдаж авах болон одоогийн сервер, тоног төхөөрөмжийг өргөтгөх чиглэлээр худалдан авалт хийхээр нийт 1,061,274,656 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг нийлүүлэгч талуудтай байгуулаад байна. Энэ нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн 15% буюу “Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа”-нд зориулагдах 1,247,994,608 төгрөгөөс зарцуулагдах юм.

2024 оны эхний хагас жилийн байдлаар тус гэрээний дагуу худалдан авалтын урьдчилгаа төлбөрт нийт 609,777,709 төгрөгийг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс зарцуулаад байна.